



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/436

Улаанбаатар хот

Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Зөрчлийн тухай хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 0064310 дугаартай шийтгэлийн хуудас, 02-12/7167 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Энхбаярын Эрхжаргалын ИЭ0010055 сери, 0010055 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. Хүний их эмч Э.Эрхжаргалын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох эрх үүстэл буюу 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон нэг жилийн хугацаанд "Нүүр амны мэс засал судлал"-ын үндсэн мэргэшлийн сургалтаас чөлөөлөх талаар Анагаахын шинжлэх шинжлэх ухааны үндэсний их сургууль /Ж.Цолмон/-д албан бичгээр мэдэгдэх;

2.4 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Нүүр амны мэргэжлийн салбар зөвлөл /Б.Амарсайхан/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо, Нийслэлийн Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Нарангэрэл/-д албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ